



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



ЭРҮҮЛ МЭНД

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:


Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

1. Зурагт “Х”-ээр тэмдэглэсэн шүдний бүтцийн нэрийг сонгоно уу.



- A. Зөөлц
- B. Тугалмай
- C. Паалан
- D. Буйл

2. Шүд хорхойтох буюу цоорох өвчнөөс сэргийлэх аргуудыг сонгоно уу.

1. Гараа тогтмол угаах
2. Чихэрлэг хүнснээс татгалзах
3. Хүнсний ногоогоо ариутгаж хэрэглэх
4. Шүдээ хоол идсэний дараа тогтмол угаах
5. Сүү цагаан идээ, хүнсний ногоо аль болох хэрэглэхгүй байх

- A. 1,2
- B. 2,3
- C. 2,4
- D. 1,5

3. Дотуур хувцсыг “30 хэмийн дулаан усанд гараар угааж болно” гэдгийг ямар тэмдэглэгээнүүдээр илэрхийлэх вэ?



- A. 1, 2
- B. 2, 4
- C. 2, 5
- D. 1, 4

Бичвэр болон хүснэгтэн мэдээлэл ашиглан 4-6 дугаар асуултад хариулна уу.

Бидний өдөр тутам хоол хүнсээр авдаг шим бодисууд бие махбодод задрахдаа 1 г уураг 4 ккал, 1 г нүүрс ус 4 ккал, 1 г өөх тос 9 ккал илчлэг өгдөг.

“Амуу” хөх тарианы талхны 100 г-д агуулагдах шимт бодисын хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

100 гр талхны шим тэжээлийн үзүүлэлт	
Уураг	11.27 г
Тослог	6.73 г
Нүүрс ус	26.78 г

4. Нэг талх 300 г байдаг. Үүнд агуулагдах нийт илчлэгийн хэмжээг зөв тооцоолсон хувилбарыг сонгоно уу.

- A. 44.78 ккал
- B. 134.34 ккал
- C. 212.77 ккал
- D. 638.31 ккал

5. 11-14 насны эрэгтэй хүүхэд өдөрт 2500 ккал илчлэгтэй хоол хүнс хэрэглэх ёстой байдаг. Энэ насны хүүхэд өдөр бүр 100 г “Амуу” талх хэрэглэдэг бол нийт илчлэгийн хэдэн хувийг энэхүү талхнаас авдаг болохыг тооцоолно уу.

- A. 25.53% B. 8.51% C. 5.37% D. 1.79%

6. “Амуу” талхны найрлагын ихэнх хэсгийг ямар шим бодис эзэлж байна вэ?

- A. Уураг B. Өөх тос C. Нүүрс ус D. А витамин

7. Сурагч Б 40 кг жинтэй бол түүний өдөрт уух усны зохист хэмжээг зөв тооцоолсон хувилбарыг сонгоно уу.

- A. 4 аяга B. 5 аяга C. 6 аяга D. 7 аяга

8. Сэтгэл хөдөлсөн үед хүмүүс бие махбодын болон сэтгэхүйн хариу үйлдэл үзүүлдэг. Сэтгэхүйн хариу үйлдлийг сонгоно уу.

- A. Зүрх дэлсэх B. Дотор муухайрах
C. Нүүр улайх D. Найз руугаа очмоор санагдах

9. Уураа зохицуулах хамгийн эрүүл, оновчтой аргуудыг зөв илэрхийлсэн мөрийг сонгоно уу.

	Цэвэр агаарт алхах	Хашгирах, чанга орилох	10 хүртэл тоолох	Таагүй орчныг орхих	Юм нүдэх, цохих
A	✓	✓			✓
B			✓	✓	✓
C		✓	✓	✓	
D	✓		✓	✓	

10. Эмийн зөв хэрэглээнд хамаарах хувилбарыг сонгоно уу.

- A. Эмчийн заавар, зөвлөмжөөр хэрэглэх
B. Олон эмийг нэг дор хэрэглэх
C. Эмийг хувь хүнээс худалдан авч хэрэглэх
D. Эмийг шошгоос өөр нөхцөлд хадгалан хэрэглэх

11. Цахим донтолтын улмаас бие махбод болон сэтгэл зүйд гарах өөрчлөлтийг ялган зөв харгалзуулсан хэсгийг сонгоно уу.

1. Бие махбодод гарах өөрчлөлт	A. Хараа муудах B. Анхаарал дутмагших C. Ясны нягт буурах, хэврэгших
2. Сэтгэл зүйд гарах өөрчлөлт	Г. Нойрны мөчлөг алдагдах D. Нийгмийн идэвхгүй болох

- A. 1-А,В,Д 2- Б,Г B. 1-А,В 2-Б,Г,Д
C. 1-Б,Д 2-А,В,Г D. 1-А,В,Г 2-Б,Д

12. Найз нөхдийн хоорондох эрүүл бус харилцаа холбооны шинж чанарыг сонгоно уу.

- A. Дарамт, шахалт үзүүлэх
B. Сонирхдог зүйлийг нь хамт хийх
C. Зөв зүйлд татан оролцуулах
D. Санааг нь дэмжиж, туслах



13. Гадуурхлын хэлбэрт хамаарах жишээг сонгоно уу.

- A. Шашин шүтлэг өөр тул сургуулийн мэтгэлцээний клубэд оруулдаггүй
- B. Намхан ч гэсэн волейболын секцэд хичээллэх боломжтой
- C. Хөгжлийн бэрхшээлтэй ч сургуулийн зургийн дугуйланд хичээллэдэг
- D. Шинжлэх ухааны клубэд сонирхлоороо аль ч ангийн хүүхэд элсэх боломжтой

14. Ахуйн гэмтэлд хүргэж болзошгүй зүйлийг сонгоно уу.

- A. Хогоо шүүрдэх
- B. Гал түлэх
- C. Ном унших
- D. Тоосоо арчих

15. Дараах тохиолдлуудад үүсэж болох эрсдэлээс өөрийгөө хамгаалах арга замуудыг зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу.

- 1. Аялал зугаалгаар явах
 - 2. Зам хөндлөн гарах
 - 3. Амьтны хүрээлэн үзэх
 - 4. Ой модоор зугаалах
- A. Танихгүй жимсийг шууд идэж болохгүй.
 - B. Цаг агаарын мэдээ үзэж, хувцсаа тохируулах.
 - B. Явган хүний гарцаар ногоон гэрлээр гарах.
 - Г. Араатан амьтдыг алсаас ажиглах.
- A. 1B 2B 3Г 4A
 - B. 1B 2B 3A 4Г
 - C. 1B 2Б 3Г 4A
 - D. 1B 2Б 3A 4Г

Бусад хүмүүсийн тухай өөрийнхөө бодлыг эргэцүүлэн хариултын хуудсанд зааврын дагуу бөглөнө үү.

Доорх зүйлс чамтай хэр тохирч байна вэ?	Би огт тэгдэггүй.	Надтай бага зэрэг адилхан.	Надтай нилээд адилхан.	Би яг тэгдэг.
16. Надад байгаа зүйл хэн нэгэнд байхгүй бол би өрөвддөг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
17. Хүмүүс яагаад янз бүрийн үйлдэл гаргадаг вэ гэдгийг би сайн ойлгодог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
18. Хүмүүст хэцүү байгааг хараад би өрөвддөг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
19. Би бусдад юм хэлэхээсээ өмнө тэрэнд ямар санагдаж байгаа бол гэж боддог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
20. Миний зөв гэдгийг мэдэж байгаа үед бусдын юу гэх надад хамаагүй.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
21. Би бусдад муухай зүйл хэлэхээсээ өмнө түүнд ямар санагдах бол гэж байнга боддог.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
22. Би бусдын сэтгэл санаа ямар байгаа бол гэдэгт санаа тавьдаг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
23. Би юмыг олон талаас нь бодож үздэг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
24. Бусдыг загнаж байгаа хүн муухай харагддаг.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D
25. Бусдад хэцүү байгаа ажилд би санаа тавьдаггүй.	<input type="radio"/> A	<input type="radio"/> B	<input type="radio"/> C	<input type="radio"/> D